



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2022 оны 05 сарын 25 өдөр

Дугаар 308

Улаанбаатар хот

“Үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийн”
арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх
тусгай зөвшөөрлийг сэргээх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


1. “Ди Пи Юу Эс” ХХК-ийн үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сэргээсүгэй.

2. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2022 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн 203 дугаар тушаалыг хүчингүй болгох талаар холбогдох арга хэмжээг авсугай.

3. Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааг эрхлэхдээ дахин зөрчил дутагдал гаргасан тохиолдолд үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгохыг анхааруулж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг “Ди Пи Юу Эс” ХХК /Х.Шинэцэцэг/-д анхааруулсугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, Улсын бүртгэлийн ерөнхий газарт ажлын 10 хоногийн дотор мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН